

## MNS ISO 4225:2001

- 3.83. **суулгах өрөө:** хийн урсгал дахь эгэл хэсгүүдийн доош суух процесст дэмжлэг үзүүлэхийн тулд хийн хурдыг сааруулах зориулалттай өрөө
- 3.84. **утаа манан:** байгалийн үзэгдлийн үр дагавраар явагддаг аэрозол болон хүний үйл ажиллагааны улмаас үүсдэг агаар мандлыг хүчтэй бохирдуулах процесс
- 3.85. **утаа:** нүдэнд харагддаг аэрозол нь голцуу шаталтаас үүдэлтэй.
- 3.86. 3.38, 3.39, 3.38-ыг үз. Шатаж байгаа бүх хий болон тэдний агуулж байгаа бодисууд
- 3.87. **хөө тортог:** яндангийн хананаас унаж байгаа болон утааны хамт гадагшлаад ойр орчмын газарт унаж байгаа тортог, агломерат
- 3.88. **яндангийн хөө тортог:** бүрэн бус шаталтаас үүсч агаарт хаягдахынхаа өмнө доош суудаг карбонт эгэл хэсгүүд
- 3.89. эх үүсвэр: 3.29-ийг үз.
- 3.90. **Тогтвортой байдал /агаар мандлын/:** Энэ нь анхныхаа түвшнээс хөдөлсөн багц агаар түүнийг буцаан байрлалд нь оруулах гэсэн гидростатистик хүчний нөлөөнд орох гидростатистикийн тэнцвэртэй байдал юм. Хэрвээ хөдөлж байгаа багц агаар нь гидростатик хүчний нөлөөнд ороогүй бол түүнийг нейтраль тогтвортой байдал гэнэ; харин гидростатик хүч нь тэрхүү багц агаарыг анхны түвшнээс нь холдуулах үйлчлэл үзүүлж байгаа бол түүнийг статистик тогтворгүй байдалд байх гэнэ.
- 3.91. **Жинлэгдсэн /хөвөгч/ бодисууд:** энэ бол агаар мандал болон яндангийн утаанд удаан хугацаагаар байсаар байх бүх өчүүхэн эгэл хэсгүүд юм. Тэд хэтэрхий эгэл учир тэдэнд газарт татагдан унах хурд гэж байраг байдаггүйтэй энэ нь холбоотой.
- 3.92. **өчүүхэн металлууд:** агаар мандал дахь металлын агууламж тун өчүүхэн бага байна.
- 3.93. **дамжих /германаас орж ирсэн хэллэг/:** бохирдуулагчийг тээвэрлэх болон түүнд агаар мандлын зүгээс үзүүлэх хариу хавсарсан үйлдэл
- 3.94. **хийн хэлбэр:** бодисууд шингэн ба хатуу бодис нь байдалд зарим тохиолдолд хийн хэлбэртэй байдаг
- 3.95. **угааж зайлуулах:** агаар мандлаас хий болон зарим бодисыг борооны дуслын тусламжтайгаар зайлуулдаг, заримдаа үүнийг бороо гэсэн тодорхойлолтонд оруулдаг.
- 3.96. **Ажлын байрны агаар:** ажлын цагаар, эсвэл ажлын байранд /дотор, гадаа ялгаагүй/ хүнийг хүрээлэн агаар нөхцөл байдал

ТӨГСӨВ.

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 13.040.01

<p style="text-align: center;"><b>Байгаль орчин. Агаарын чанар. Нийтлэг үндэслэл. Тайлбар толь</b></p> <p style="text-align: center;"><b>Environment. Air quality. General aspects. Vocabulary.</b></p>	<p><b>MNS ISO 4225 : 2001</b></p>
---	-----------------------------------

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн зөвлөлийн 2001 оны 04-р сарын 26-ний өдрийн 21 дугаар тогтоолоор батлав.

2001 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

### 1. Хамрах хүрээ

Олон улсын энэхүү стандарт нь агаарын чанарыг тодорхойлохын тулд хий, уур, эгэл хэсгүүдийг хэмжих болсон дээж авахтай холбоотойгоор нийтлэг хэрэглэдэг нэр томъёог сонгон авч ямар утга санаа илэрхийлж байгааг нь англи, франц хэл дээр тайлбарласан болно.

Эдгээр нэр томъёог англи цагаан толгойн дарааллаар байрлуулсан.

### 2. Норматив ишлэл

Доор дурьдсан стандартууд нь энэхүү стандартад иш татсан утгаараа уг олон улсын стандартын нөхцлүүдийг бүрдүүлэх зүйлсийг өөртөө агуулсан болно.

Хэвлэн бэлтгэх үед дурьдсан хэвлэл нь хүчин төгөлдөр байсан. Бүх стандартууд нь хянан, шинэчлэж болдог зүйл бөгөөд энэхүү олон улсын стандартад тулгуурлан гэррээ хэлцэл хийгч талууд нь хамгийн сүүлийн үеийн хэвлэлүүдийг ашиглах боломж байгаа талаар эрэл хайгуул хийх нь зүйтэй.

ОУЭТК, ОУСБ-ын гишүүн орнууд одоогийн байдлаар хүчин төгөлдөр байгаа олон улсын стандартуудыг бүртгэж авдаг.

ISO 9169 – Агаарын чанар- Хэмжих аргуудын гүйцэтгэх мөн чанарыг тогтоох

### 3. Нэр томъёо, тодорхойлолт

- 3.1. **бууруулах:** ялгарч буй хий, бохирдуулагчийн хэмжээг бууруулах
- 3.2. **аэрозол:** хийн орчин дахь хатуу, шингэн төлөвт байгаа хатуу, шингэн эгэл хэсгүүд буюу суултын хурд нилээд багатай, тоосонцор хэлбэрийн эгэл хэсгүүд
- 3.3. **агаар бохирдуулагч:** хүний үйл ажиллагаа, байгалийн үзэгдлийн явцад агаарт хөөрч, хүн ба хүрээлэн байгаа орчинд таагүй нөлөө үзүүлдэг материал

## MNS ISO 4225:2001

- 3.4. **агаарын бохирдол:** агаарт хүний үйл ажиллагаа болон байгалийн үзэгдлийн явцад агаар мандал руу дэгдэн гарч хүн, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлдэг ямарваа нэгэн материаллаг зүйлс
- 3.5. **Айткен нуклей:** Атмосферийн 1 миллиметр агаарт хэдэн мянгаас хэдэн түм хүртэл тоогоор байгаа 0.1мкм –ээс бага хэмжээний хөндлөн огтлол бүхий өчүүхэн жижиг эгэл хэсгүүд. Тэдгээр нь хүний үйл ажиллагаа ба байгалийн үзэгдлийн үр дүнд агаарт дэгдэн хөөрдөг. Мөн түүнчлэн тэдгээр нь физик химийн үзэгдлийн үр дүнд агаар мандалд үүсэн бий болно.
- 3.6. **хүрээлэн буй орчны агаар:** хүн, амьтан, ургамал, материалын нөлөөнд орж байгаа гадаад орчны агаар
- 3.7. **хүрээлэн байгаа агаарын чанар:** хүрээлэн байгаа агаарын байдлыг бохидлын зэргээр нь харуулсан үзүүлэлт
- 3.8. **хүрээлэн буй орчны агаарын чанарын стандарт:** хүрээлж буй агаарын чанарыг тухайн цаг хугацааны мөчлөгт агаар бохирдуулагчийн агууламжид статистикийн аргаар хязгаар тогтоосон үзүүлэлт
- 3.9. **аррестер:** хийн орчноос эгэл хэсгүүдийг ялган авах төхөөрөмж
- 3.10. **үнс:** нүүрс төрөгч бүхий материалын шатаалтаас үлдсэн хатуу биет үлдэгдэл. Үнс нь бүрэн шатаагүй түлшийг өөртөө агуулдаг. Тиймээс шинжилгээ хийхийн тулд бүрэн шаталт явагдсан байх шаардлагатай.
- 3.11. **агаар мандал /дэлхийн/:** манай дэлхийг бүрхсэн агаарын масс
- 3.12. **дундаж хугацаа:** агаарын чанарыг дундажлан авч үзэх цаг хугацааны мөчлөг /хэмжилтийн аргыг ISO 9169-өөс үз/
- 3.13. **үндсэн агууламж /агаарын бохирдлын/:** судлагдаж байгаа зүйлтэй шууд холбоогүйгээр агаарын чанарыг тодорхойлогч зүйл
- 3.14. **цүнхэн шүүлтүүр:** хийн урсгалаас эгэл хэсгүүдийг шүүж авах зориулалттай тодорхой хэлбэр оруулсан даавуун шүүлтүүр
- 3.15. **байрны шүүлтүүр:** гаднах байгууламжийг хамгаалахын тулд түүний дотор байрлуулсан чингэлэг рүү эгэл хэсгүүдийг барьж, шүүн оруулах зориулалттай шүүлтүүр, тусгай механизмаас бүрдсэн цогц төхөөрөмж /3.14-ийг үз/
- 3.16. **амьсгалын бүс:** хүний амьсгалж буй агаар мандлын тодорхой хэсэг. Энэ нь ойролцоогоор 3 дм радиустай хагас бөмбөрцөг бөгөөд хүний хоёр чихийг холбосон шугамны дунд, нүүрний өмнөд хэсэгт оршино. Энэхүү хөгс бөмбөрцгийн суурь нь энэ шугам, хүний толгойн орой, хоолой зэргээр дайрч гарна.
- 3.17. **цацруулагч цорго:** шингэнийг шингээх орчны дундуур хий урсгах зориулалттай төхөөрөмж . Хийн оруулах хоолой нь шингэний гадаргаас доор байрлах бөгөөд шингэнд хийг хэсэгчилсэн байдлаар өгөх зориулалтын төхөөрөмжтэй байж болно.

- 3.18. **эгэл хэсэг баригч импульсэн төхөөрөмж /барилгын гадна байрлуулдаг/:** орчны шинжээс хамаарч янз бүрийн хэмжээтэй эгэл хэсгүүдийг тус тусад нь барьж цуглуулах төхөөрөмж
- 3.19. **яндангийн нөлөө:** агаарын температурын зөрөөний үйлчилээр агаар болон хийн масс доороосоо дээшээ чиглэсэн урсгал, хөдөлгөөнд орох үзэгдэл
- 3.20. **уналт:** эгэл хэсгүүдийн хэмжээнээс хамаарч суурилуулсан тоног төхөөрөмжийн заалт тусгайлсан нөхцөл байдлын үеийнхээс доош орж ирэх
- 3.21. **циклон:**
- 1/ төвөөс зугтах хүчний үйлчиллийг ашиглан хийсэн тоос, эгэл хэсгийг ялгах центрифуг нь хийн хөдөлгөөний зарчим дээр тулгуурласан байдаг
- 2/ атмосферийн даралт багатай газарт салхины хуйлралын том системийг ашигладаг
- 3.22. **дисперсийн параметрууд /гаусиан/:** сигма хэмжигдхүүний хувьд эдгээр нь хийн хөөрөх зам, түүнийг туулах хугацааг тодорхойлоход чухал үүрэгтэй Гаусианы параметруудыг тодорхойлдог. Тэдгээр нь атмосферийн тогтвортой байдлаас их хамаарна.
- 3.23. **дусал:** багахан хэмжээ, нягтшилтай шингэний хэсгүүд болон турбулент нөхцөлд жинлэгдсэн хэлбэрт байх эгэл хэсгүүд /200 мкм-ээс бага хэмжээтэй/
- 3.24. **зөвшөөрөгдөх алдаа:** 3.53-ыг үз
- 3.25. **тоос:** Нийтээр хүлээн зөвшөөрснөөр 75мкм-ээс бага хэмжээтэй, жингээрээ доош суудаг боловч хэсэг хугацаанд хөвөх чадвартай хатуу эгэл биетүүд
- ТАЙЛБАР: зарим хэлэнд английн "тоос", элс тоос" гэсэн үгийг ганц үгээр орлуулдаг
- 3.26. **яндангийн нөлөөгөөр хөөрөх өндөр:** яндангаас гарах утааны хөөрөх өндрийг тооцоход үүнийг хэрэглэх бөгөөд энэ нь яндангийн өндөр, яндангаас гарах үеийн хурд, хөөрөх үзэгдэл, салхины хурд зэргээс хамаарахаас гадна тухайн газар нутгийн байршил мөн нөлөө үзүүлдэг.
- 3.27. **электростатик баригч:** хийн урсгалаас эгэл хэсгүүдийг барьж тогтоох төхөөрөмж. Өндөр хүчдэл бүхий электродуудын дундуур хийг нэвтрүүлэхэд эгэл хэсгүүд өндөр хүчдэл бүхий электродууд дээр хуримтлагдана.
- 3.28. **угаалт:** эгэл хэсгүүдийн жингээрээ доош суух хурдны ялгааг нь ашиглан эгэл хэсгүүдийг ялгах арга
- 3.29. **ялгаралт:** бодисуудын агаарт хөөрөн гардаг. Ялгаралт үүсч байгаа цэг буюу газрыг ялгаралтын эх үүсвэр гэнэ. Энэ хэллэгийг хатуу бодисын ялгаралт ба ялгаралтын зэргийг тогтооход ашигладаг бөгөөд түүнийг дуу чимээ, дулааны ялгарлын хувьд ч хэрэглэж болно.

## MNS ISO 4225:2001

- 3.30. **ялгаралт агууламж:** ялгаралт үүсч байгаа цэг дээрхи агаарын бохирдлын агууламж.
- 3.31. **ялгаралтад нөлөөлөх хүчин зүйлс:** зарим төрлийн үйл ажиллагааны үр дүнд ялгарлын зэрэг нь тухайн төрлийн бохирдлын хэмжээнд хүрсний илэрхийлэл. Жишээ нь: 1 тонн ган үйлдвэрлэхэд нилээд кг хүхрийн хэт исэл ялгаран гарна.
- 3.32. **ялгарлын урсгал:** ялгарлын эх үүсвэрийн нэгж гадаргаас гарах бодисын хэмжээ
- 3.33. **ялгарлын зэрэг:** нэгж хугацаанд агаар мандалд ялгарах бохирдуулагч бодисын масс, /буюу физикийн бусад чанар/
- 3.34. **ялгарлын стандарт:** Тогтмол байрлалтай бохирдуулагч бодисын ялгарлын зэрэг. Бохирдлыг, эсвэл бохирдуулагч бодисын агууламжийг статистик аргаар тогтоосон түвшинд хүртэл шингэрүүлэх, эсвэл агаарыг тунгалаг болгох хязгаар юм.
- 3.35. **эквивалент диаметр:** судалж шинжилсэн эгэл хэсэгтэй геометр, гэрэл, цахилгаан, аэродинамикийн шинж чанараараа адил диаметртэй эгэл хэсгүүд
- 3.36. **тортог:** яндангаас гарсан утаанд агуулагдах нэг нэгнээсээ сайтар тусгаарлагдсан, сайн ялгарсан утаа тортог
- 3.37. **манан:** хий дотор хөвж байгаа уурын эгэл хэсгүүд. Үүнийг "1 километр дотор холын зай харагдахгүй болгох уурын дуслууд" гэж цаг уурын хэллэгээр тодорхойлдог.
- 3.38. **утаа:** хатуу эгэл хэсгүүдийн аэрозол. Төмөрлөгийн үйлдвэрийн процесст хийн төлөвт байгаа бодисууд конденсацид орох, хайлсан бодисууд уурших зэрэгт хүчилтөрөгчжих гэх мэтийн химийн урвалын явцад үүсдэг хуурай бодисын аэрозол.
- 3.39. **Утаа:** ерөнхийд нь энэ бол химийн үйлдвэрээс гардаг, таатай бус, өмхий үнэртэй агаарын урсгалаар тархдаг хатуу бодис.
- 3.40. **Холилдох, байраа солих:** дээд давхаргад хуримтлагдсан бохирдуулагч бодисууд турбулент хөдөлгөөн үүсгэдэг цаг уурын үзэгдлийн нөлөөгөөр гэнэтхэн газрын давхаргад буух
- 3.41. **Элс, тоос:** атмосферийн урсгалд эгэл хэсгүүд солигдож, холилдох
- 3.42. **.../3.25-аас үз/:** энэ нь янз бүрийн хэмжээ, гаралтай эгэл хэсгүүд хэсэг хугацаанд агаар хөвсөн байдалтай байх үзэгдэл
- 3.43. **агууламжийн доод хэмжээ:** газраас тодорхой өндөрт хэмжсэн агаарын нэгж эзлэхүүнд байх хатуу, шингэн, хийн төлөвт байгаа биетийн тоо хэмжээ.

- 3.44. **будан:** энгийн нүдээр харахад түвэгтэй боловч агаарт байх маш эгэл хэмжээтэй уурын дуслууд нь үзэгдэх байдлыг бууруулж, агаарыг цагаавтар өнгөтэй болгон харагдуулна.
- 3.45. **Иммишн буюу ялгарлын эсрэг үзэгдэл:** агаар мандал дахь бохидуулагч бодисууд тэдгээрийг хүлээн авах чадвартай ямар нэгэн биет зүйл рүү буцаж буух. Энэ нь агууламжийн доод хэмжээ мэтийн зарим ойлголтыг хэрэглэдэггүй боловч ялгаралт гэх мэтийн ойлголтыг өөртөө тусгадаг. Жишээ нь: бохирдуулагч бодис хүний амьсгалаар дамжин уушгинд нэвтрэн орох гэх мэт.
- 3.46. **Иммишний доз:** тодорхой хугацаанд бохирдолд өртөгч рүү нэвтэрч байгаа бодисын хэмжээ
- 3.47. **Нэгжид ногдох иммишн:** өртөгчийн нэгж гадаргад нэвтэрч буй бодисын тоо хэмжээ
- 3.48. **Иммишний зэрэг:** өртөгчид нэгж хугацаанд нэвтэрч байгаа бохирдуулагчийн тоо, хэмжээ бусад физик чанар
- 3.49. **Дээж авагч:** эгэл хэсгүүд болон хийг цацруулах болон цуглуулах зориулалттай төхөөрөмж
- 3.50. **доторх агаар:** барилга байгууламж, олон нийтийн газар зэрэг битүү, хаалттай орчны агаар
- 3.51. **хэмжилтэнд нөлөө үзүүлэх:** агаарын дээжийн аливаа хэмжилтийн үр дүнд нөлөө үзүүлдэг бүрэлдэхүүн хэсэг
- 3.52. **изогенетик дээж авалт:** дээж авах хурд нь дээж авах цэг дэх хийн урсгалын хурдтай тэнцүү байх
- 3.53. **хүлцэх алдаа:** атмосферын шинж чанар нь өндрөөс шалтгаалж янз бүрийн хувилбартай, температурын ялгааг ч мөн тооцох шаардлагатай.

Өндөрсөх тусам атмосферийн температур буурна гэсэн хувилбар нь ерөнхийдөө зөв. Хэрвээ атмосферийн агаар нь хуурай агаартай төстэй байдаг бол /өөрөөр хэлбэл 1 км-т 10 хэм хөрдөг/ зөвшөөрөгдөх алдааг ч мөн түүнтэй адилаар авч болох юм.

- 3.54. **Хэмжилт үргэлжлэх хугацаа:** эхний ба сүүлчийн хэмжилтийн хоорондох хугацаа
- 3.55. **Микро цаг-уур судлал:** атмосферт явагддаг физик, динамикийн процесс буюу тэрхүү явцуухан хүрээний асуудлыг судалдаг шинжлэх ухааны нэг хэсгийг микро цаг уур судлал гэнэ.

Тэхлээр микро цаг уур судлал нь атмосферийн гадарга, газрын гадарга хоёрын хоорондох тэрхэн давхрага дахь агаарын хөдөлгөөнийг л судалдаг байна.

## MNS ISO 4225:2001

- 3.56. **бүрхэгшилт:** хий дахь уурын дусалтай холбоотой, утга нь нэлээн бүрхэгдүү үг хэллэг. Цаг уурчдын хэллэгээр энэ нь будантай төстэй боловч үзэгдэх зай нь 1 км-ээс арай хол, 2 км-ээс арай ойр байдаг.
- 3.57. **хяналт- шинжилгээ:**
- 1/ өргөн утгаар нь авч үзвэл урт удаан хугацааны турш гарч байгаа өөрчлөлтийг хэмжих
- 2/ явцуу утгаар бол, дүрэм журам, хяналтын үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд бохирдлын хэмжээг стандартын шаардлагад тохирч байгаа эсэхийг тогтмол шалгах
- 3.58. **сар:** биднийг хүрээлж байгаа агаарын чанарын талаар хоорондоо уялдаа холбоо бүхий дүн шинжилгээ хийж, тайлагнах хугацаа, өөрөөр хэлбэл 30 хоног
- 3.59. **байгалийн жамаар бий болдог агууламж:** хүний үйл ажиллагаанаас үүсдэг бохирдуулагчийн тун ялимгүй бага агууламж өөрөөр хэлбэл байгалийн жамаараа бий болсон агаарын масс дахь бохирдуулагчийн агууламж
- 3.60. **үнэртэй бодис:** өвөрмөц, онцгой үнэртэй бодис
- 3.61. **үнэр:** үнэрийн мэдрэмж төрүүлдэг бодисын онцгой чанар
- 3.62. **үнэрлэх бүлгийнхэн /үнэрийн тестерүүд/:** бодисыг үнэрийн зэрэглэлээр нь ангилах, үнэрийн хувьд тухайн бодис нь ямар ангилалд багтдаг болохыг тодорхойлох ажилтай хэсэг бүлэг хүн
- 3.63. **үнэрийн босго:** эвгүй үнэр гарч байгааг мэдэрч эхлэх, эсвэл үнэр гарч байгааг хүлээн зөвшөөрөх гэсэн хоёр үндсэн утгатай.
- 3.64. **Эвгүй үнэр гарч байгааг мэдрэх босго:** бохирдуулагчийн агууламж нь оршин суугчдын тэн хагас нь эвгүй үнэр гарч байгааг мэдрэх хэмжээнд хүртэл нэмэгдэнэ. Энэ босгыг тогтоохын тулд үнэрлэх бүлгийнхэн хүн амын давхаргын төлөөлөгчдийг оролцуулан туршилт хийнэ.
- 3.65. **үнэр гарч байгааг хүлээн зөвшөөрөх:** оршин суугчдын тэн хагас нь үнэр гарч байгааг хүлээн зөвшөөрнө. Энэ босгыг тогтоохын тулд үнэрлэх бүлгийнхэн хүн амын давхаргын төлөөлөгчдийг оролцуулан туршилт хийнэ.
- 3.66. **Эгэл хэсэг:** маш бага хэмжээний хатуу, шингэн бодисын масс
- 3.67. **фотохимийн урвал:** зарим бодис ягаан, хэт ягаан туяаны цацрагийн үйлчилэлд ороход явагддаг урвал
- 3.68. **фотохимийн утаа:** нарны гэрлийн нөлөөгөөр атмосфер дахь нитрогенийн исэл, органик бүрэдлүүдэгчид, исэлдүүлэгчдийн хооронд урвал явагдсанаар, цаашилбал бохирдуулагчийн агууламж ихсэх нь исэлдүүлэгч

бодисууд үүсэх буюу үзэгдэх баримжаа муудах, нулимс урсах, материал, ургамлын ургах хугацаанд сөрөг нөлөө үзүүлнэ.

- 3.69. **яндангийн утаа:** яндангаас гарах утаа /ихэнхдээ нүдэнд харагдахуйц/
- 3.70. **утаа хөөрөх өндөр:** утааны агаарт хөөрсөн өндрийг гарч байгаа цэгээс нь хэмжинэ
- 3.71. **анхдагч бохирдуулагч:** эх үүсвэрээс агаар мандалд бохирдлоо шууд гаргаж байгаа бохирдуулагч. Хоёрдогч бохирдуулагч нь агаар мандалд үүсч бий болж байгаа бохирдол юм.
- 3.72. **Дээж авах төхөөрөмж:** утаа гарч байгаа хоолойгоос дээж авах зориулалттай хоолой хэлбэрийн төхөөрөмж
- 3.73. **Борооны үүлнээс дээж авах төхөөрөмж:** үүлэн дэх уурыг борооны дусал болгон зайлуулах замаар эгэл хэсгүүдийг ялган авах механизм
- 3.74. **Алсын тандалт:** шинжлэх гэж байгаа агаарын даврага дахь бохирдуулагч бодис, эгэл хэсгүүд болон цаг уурын параметруудыг шууд хүрэлгүйгээр алсаас тандах аргаар тодорхойлох
- 3.75. **ялгах чадвар:** ялгагчийн оролтон дахь эгэл бодисын хэмжээг оруулсан нийт бодисын тоонд харьцуулсан үзүүлэлт. үүнийг голцуу хувиар илэрхийлдэг.
- 3.76. **Рингелманы тоо:** яндангийн утааны харлуулалтын зэргийг 0– цагаан, 5- хар гэсэн баллаар илэрхийлсэн тоо.
- 3.77. **Дээж авах:**
- 3.77.1. **үргэлжилсэн дээж авалт:** дээжийг тогтоосон мөчлөгтэйгээр тасралтгүй авах
- 3.77.2. **гэнэтийн дээж авалт:** маш богино хугацаанд дээж авах, мөн халуун цэгээс дээж авах
- 3.78. **дээж авах мөчлөг:** дээж авалтын хоорондох хугацаа
- 3.79. **цэвэрлэгээ:** байгалийн үзэгдлийн тусламжтайгаар бохирдуулагч бодисыг агаар мандлаас зайлуулах
- 3.80. **хийн хоолойг цэвэрлэх, угаах:** хийн урсгалаас хийн болон бусад бохирдуулагчийг шингэн, нойтон гадаргуутай мөргөлдүүлэх, эсвэл шингэн цацруулагчаар угаах аргаар зайлуулах
- 3.81. **хийн хоолойг цэвэрлэх:** хийн урсгалаас хийн дээж авах, төхөөрөмжийг бохир хийнээс цэвэрлэхдээ шингэн гадаргуу, нойтон сав, дусал үүсгэгч ашиглах арга
- 3.82. **хоёрдагч бохирдуулагч:** агаар мандалд явагддаг физик, химийн үзэгдлийн үр дүнд суурин ба хөдөлгөөнт эх үүсвэрийн анхдагч бохирдуулагч болон бусад эх үүсвэрээс тэнд үүсэх бохирдол